

ЗАСГИЙН ГАЗРААС БАТАЛСАН
“ОЁМОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ” ХӨТӨЛБӨРИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2009.03.15

2008 оны жилийн эцсийн байдлаар

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2006 оны 51 дүгээр тогтоолоор баталсан “Яам, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг удирдлага болгож ХҮБХЗГ-аас гаргасан уг хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан, холбогдох статистик мэдээллүүдийг үндэслэн хийв.

Д.д	Хөтөлбөрийн агуулга	Гүйцэтгэл	
1	ЗГ-ын тогтоолын дугаар, огноо	Хөтөлбөрийг Засгийн газрын 2003.09.17-ны өдрийн 207 дугаар тогтоолоор баталсан.	
2	Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа	2003-2015 он	
3	Хөтөлбөрийн зорилго	Хөтөлбөрийн зорилго нь бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, экспортын хэмжээг тогтвортой хадгалах, дотоодын бүтээгдэхүүнээр хүн амын хэрэгцээг хангах бизнесийн таатай орчин бүрдүүлэхэд оршино.	
4	Хөтөлбөрийн зорилтууд /үе шатаар/	Зорилтууд	Хөтөлбөрийн зорилгыг хангахын тулд дараахь зорилтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд: 1. Шинэ зах зээл нээж олох, экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр гадаад харилцааг хөгжүүлж, худалдааны тааламжтай нөхцөл бүрдүүлэх; 2. Үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх эрх зүйн таатай орчин бий болгох; 3. Импортыг орлох үйлдвэрлэлийг дэмжих; 4. Салбарын менежментийг сайжруулж, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэн бүтээмжийн өсөлтийг хангах.
		I шат 2003 -2005 он	Оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэж, суурилагдсан хүч чадлын ашиглалтыг дээшлүүлэн, үйлдвэрлэлийг хэвийн өсөлттэй явуулах нөхцөлийг бүрдүүлнэ.
		II шат 2006 -2008 он	Гадаад зах зээлд салбарын эзлэх байр суурийг бататгаж, дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.
		III шат 2009 -2015 он	Оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хөгжлийг эрчимжүүлж, өрсөлдөх чадварыг Зүүн өмнөд Азийн орнуудын түвшинд хүргэнэ.
5	Хүлээгдэж буй үр дүн	1. Бүтээгдэхүүний экспорт тогтвортой нэмэгдэж, оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн дэлхийн зах зээлд эзлэх байр суурь өснө. 2. Ажлын байр нэмэгдэж, ажилгүйдэл бууруулна. 3. Орон нутагт үйлдвэрлэл хөгжих таатай орчин бүрдэнэ. 4. Салбарын үйл ажиллагааны импортоос хамаарах хамаарал буурна.	
6	Зарцуулсан хөрөнгө	Төсөв /шаардагдах нийт зардал/	I-II шатны арга хэмжээ хэрэгжүүлэх төсөв 39.0 сая төгрөг
		Гүйцэтгэл /өссөн дүнгээр/	27.25 сая төгрөг
		тухайн жилд	15 сая төгрөг

7	Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ	Биелэлтийн хувь	Дүн	75	70	65	Дундаж
		II шатны зорилт, арга хэмжээ	4	1	2	1	70%
8	Хөтөлбөрийн хэрэгжилт	Засгийн газрын 2003 оны 207 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Хөтөлбөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл”-ийн арга хэмжээ тус бүрийн хэрэгжилтийг үндэслэн хяналт-шинжилгээг хийв.					
	<p>1. Шинэ зах зээл нээж олох, экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр гадаад харилцааг хөгжүүлж, худалдааны тааламжтай нөхцөл бүрдүүлэх зорилтын хүрээнд 7 арга хэмжээ төлөвлөсөн.</p> <p>II шатны хэрэгжилт дунджаар 70 хувьтай байна.</p> <p>(70+90+90+50+90+50+50)/7</p>	<p><i>а/ Шинэ зах зээл нээж илрүүлэх, түүнд нэвтрэх, худалдааны таатай нөхцөл бүрдүүлэх чиглэлээр олон улсын байгууллага, гадаад орнуудтай гэрээ хэлэлцээр байгуулах асуудлыг судалж шийдвэрлэх, 2003-2008</i></p> <p>- Монгол Улсад үйлдвэрлэсэн нэхмэл, сүлжмэл, оёмол бүтээгдэхүүнийг АНУ-ын “Хөнгөлөлтийн ерөнхий систем”-д хамруулах санал АНУ-ын Засгийн газарт уламжилж, “Чөлөөт худалдааны хэлэлцээр” байгуулах болсон. Чөлөөт худалдааны хэлэлцээрийн эхний шат болгон Худалдаа, хөрөнгө оруулалтын Ерөнхий хэлэлцээрийг үзэглэсэн. Монгол - АНУ-ын Худалдаа, хөрөнгө оруулалтын хамтарсан зөвлөлийн хуралдааныг 3 удаа зохион байгуулав. АНУ-ын Хөнгөлөлтийн ерөнхий системийн дагуу гараар нэхсэн буюу ардын урлагийн бес даавуун бүтээгдэхүүнийг АНУ-д импортын татваргүй экспортлох боломж бүрдсэн.</p> <p style="text-align: right;"><i>Хэрэгжилт - 70.0 хувь</i></p> <p><i>б/ Хөрш болон зүүн өмнөд Азийн орнуудтай хамтран ажиллаж, Монголд үйлдвэрлэсэн оёмол бүтээгдэхүүнийг олон улсын зах зээлд нийлүүлэхэд дэмжлэг авах, 2004-2008</i></p> <p>- Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан - техникийн хамтын ажиллагааны Монгол-Хятадын ЗГХК-ын IX хуралдааны протоколд оёмол, нэхмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарт хамтран ажиллахаар тохиролцов.</p> <p>- Монгол-Оросын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг 2010 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд оёмол, сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүнд ОХУ-ын зүгээс ногдуулах импортын татвараа 2008 оны 3 дугаар сараас 2 дахин бууруулахаар тохиролцсон.</p> <p style="text-align: right;"><i>Хэрэгжилт - 90.0 хувь</i></p> <p><i>в/ Гадаад орнуудаас манай улсын оёмол бүтээгдэхүүнд ногдуулдаг гаалийн татварыг бууруулах боломжийг судалж, хэрэгжүүлэх талаар тухайн орнуудтай хамтран ажиллах, 2004-2008</i></p> <p>- Европын холбооны Ерөнхий хөнгөлөлтийн системийн хүрээнд манай улсын оёмол, сүлжмэл бүтээгдэхүүн ЕХ-ны зах зээлд импортын татваргүй нэвтрэх болсон.</p> <p>- Канад зэрэг худалдааны түнш орнуудад нийлүүлдэг оёмол, сүлжмэл бүтээгдэхүүний импортын татварыг бууруулах асуудлыг тавин Канад улс Монголоос нийлүүлэх оёмол, сүлжмэл эдлэлийн импортын татварыг 3.5 хувиар бууруулахаар тохиролцсон.</p> <p style="text-align: right;"><i>Хэрэгжилт - 90.0 хувь</i></p> <p><i>г/ UNIDO, JETRO зэрэг үйлдвэр, худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмждэг олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж, харилцан мэдээлэл солилцох, хөдөлмөрийн нөхцөл, бизнесийн орчинг сайжруулах чиглэлээр төсөл хэрэгжүүлэх, 2003-2008</i></p> <p>- АНУ-ын Эдийн засгийн бодлогын шинэтгэл, өрсөлдөх чадвар</p>					

		<p>төслийн хүрээнд олон улсын эксперт “Монголын хувцасны салбар: Квотын төгсгөлийн үр дагавар болон яаралтай авах арга хэмжээ”-ний санал бэлтгэв.</p> <p style="text-align: right;"><i>Хэрэгжилт - 50.0 хувь</i></p> <p><i>д/ Монголд хөрөнгө оруулагчдыг дэмжих Олон улсын чуулга уулзалтаар “Оёмол, сүлжмэл бүтээгдэхүүн ба Made in Mongolia” тусгай булан нээж ажиллуулах, сурталчилгааг өргөжүүлэх, 2004-2008</i></p> <ul style="list-style-type: none"> - “Монголд үйлдвэрлэв” худалдааны төвд Монголд үйлдвэрлэсэн оёмол, сүлжмэл эдлэлийн тусгай тасгууд ажиллаж байна. Бизнес эрхлэгчдийн Их чуулганд оёдлын үйлдвэрүүдийн бүтээгдэхүүний талаар зурагт сурталчилгаа гаргав. - Гадаадын хөрөнгө оруулагчдын чуулга уулзалтын үеэр Хөнгөн үйлдвэрийн салбар хуралдаанд оёмол сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэл эрхлэгчдийн уулзалтыг зохион байгуулав. - Мишээл экспо төвд “Монголд үйлдвэрлэв” үзэсгэлэн худалдааг 2 жилдээ зохион байгуулж оёдлын салбарын шилдэг бүтээгдэхүүнээр “Зорбиом” ХХК-ийн эрэгтэй костюм шалгарсан. <p style="text-align: right;"><i>Хэрэгжилт - 90.0 хувь</i></p> <p><i>е/ “Magic Show” /АНУ/, “Inter Stuff” /ХБНГУ/, “Prete-a-Porte” /Франц/ зэрэг олон улсын төрөлжсөн үзэсгэлэн, яармагт монголын үйлдвэрлэгчид оролцох, үйл ажиллагаагаа сурталчлахад нь дэмжлэг үзүүлэх, 2004-2008</i></p> <ul style="list-style-type: none"> - ХБНГУ-ын Берлин хотод зохион байгуулсан “Монголын аялал, жуулчлалыг дэмжих” үзэсгэлэнд монголын үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийг оролцуулав. <p style="text-align: right;"><i>Хэрэгжилт - 50.0 хувь</i></p> <p><i>ё/ Монголын оёмол бүтээгдэхүүний гадаад, шинэ зах зээлийн талаар мэдээлэл, судалгаа гаргаж үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийг хангах, бизнес эрхлэгчдийн хооронд холбоо харилцаа тогтооход дэмжлэг үзүүлэх, 2003-2008</i></p> <ul style="list-style-type: none"> - Монголын оёмол бүтээгдэхүүний гадаад зах зээлийн талаар судалгаа гаргаж хэрэглэгчид хүргэв. - ХБНГУ-ын техникийн хамтын ажиллагааны “ДХБ ба худалдааны бодлого” төслийн хүрээнд оёмол бүтээгдэхүүний зах зээлийг өргөжүүлэх судалгаа хийж, зөвлөмж гаргасан. <p style="text-align: right;"><i>Хэрэгжилт - 50.0 хувь</i></p>
	<p>2. Үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх эрх зүйн таатай орчин бий болгох зорилтын хүрээнд 2 арга хэмжээ төлөвлөсөн.</p> <p>II шатны хэрэгжилт 70 хувьтай байна.</p>	<p><i>а/ Оёмол бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд шаардлагатай түүхий эд, материалын гаалийн татварын төлөлт, зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр Гаалийн тарифын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг судалж боловсруулах, 2004-2005</i></p> <ul style="list-style-type: none"> - Оёмол бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд шаардлагатай түүхий эд, материалын гаалийн татварын төлөлт, зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр “Зарим төрлийн барааг гаалийн албан татвараас чөлөөлөх”, “Зарим төрлийн барааг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх” тухай хуулиудыг УИХ-ын 2005 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан. <p style="text-align: right;"><i>Хэрэгжилт - 90.0 хувь</i></p> <p><i>б/ Экспортод бүтээгдэхүүнээ гаргадаг үйл ажиллагаа нь</i></p>

		<p><i>тогтворжсон дотоодын үйлдвэрлэгчдийг зээлийн бодлогоор дэмжих механизмыг хэрэгжүүлэх, 2003-2008</i></p> <p>- Экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг компаниудад олгодог зээлийн хүүг бууруулж, дээд хэмжээг 2.0 хувиас ихгүй байлгах бодлогыг арилжааны банкууд баримтлан ажиллав.</p> <p>- Хөрөнгө оруулалт, хөгжлийн сангийн хүүгийн урамшуулал, Япон улсын 2 үе шаттай зээлд үйлдвэр, аж ахуйн нэгжүүд хамрагдах боломжтой болсон. Хэрэгжилт - 70.0 хувь</p>
	<p>3. Импортыг орлох үйлдвэрлэлийг дэмжих зорилтын хүрээнд 4 арга хэмжээ төлөвлөсөн.</p> <p>II шатны хэрэгжилт дунджаар 65 хувьтай байна.</p> <p>(90+70+70+30)/3</p>	<p><i>а/ Улсын захиалгын бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийг шалгаруулах уралдаант шалгаруулалт/тендер/-д дотоодын үйлдвэрлэгчдийг хамруулах хүрээг өргөжүүлэх, 2004-2008</i></p> <p>- Оёдлын салбарын өмнө тулгарч буй бэрхшээлийг шийдвэрлүүлэх үүднээс Засгийн газрын 2004 оны 237 дугаар тогтоолыг батлуулан хэрэгжүүлж байна. Уг тогтоолын 3-т төсвийн болон орон нутгийн өмчөөр бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дотоодын үйлдвэрүүдийн бүтээгдэхүүнийг тэргүүн ээлжинд сонгох, захиалгат бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч дэмжлэг үзүүлэхээр заасны дагуу холбогдох судалгаа, саналыг боловсруулж Сангийн яам, Батлан хамгаалах яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн.</p> <p>- Их бүтээн байгуулалт-шинэ ажлын байр нэмэгдүүлэх жил болгон зарласантай холбогдуулан төсвийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бүтээгдэхүүн, бараа үйлчилгээнд дотоодын үйлдвэрүүдийг тэргүүн ээлжинд хамруулж, бараа бүтээгдэхүүнийг худалдан авах талаарх саналыг Сангийн яаманд хүргүүлсэн. Дотоодын үйлдвэрлэгч, аж ахуйн нэгжийг дэмжих зорилгоор “Тендерт оролцогчид давуу эрх олгох аргачлал”-ыг Сангийн сайдын 2007 оны 81 тоот тушаалаар батлуулсан.</p> <p>Хэрэгжилт - 90.0 хувь</p> <p><i>б/ Хувцас захиалга, засварын болон үндэсний хувцас үйлдвэрлэх жижиг, дунд үйлдвэрийг орон нутагт хөгжүүлэхэд санхүү, зээлийн дэмжлэг үзүүлэх, 2004-2008</i></p> <p>- “Орон нутагт 2010 он хүртэл үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэл”-ийг хэрэгжүүлэх хүрээнд бүсийн тулгуур төвүүдэд хувцас захиалгыг жижиг үйлдвэрүүдийг байгуулах, сэргээх төслүүдийг дэмжиж, лизингийн зээл олгоход хамруулсан.</p> <p>Хэрэгжилт - 70.0 хувь</p> <p><i>в/ Шошго, тэмдэг, сав баглаа, боодлын жижиг үйлдвэр байгуулах бизнес эрхлэгчдийн санаачлагыг дэмжих, 2003-2008</i></p> <p>- Шошго, тэмдэг, сав баглаа, боодлын жижиг үйлдвэр байгуулж, ашиглах эдийн засгийн ач холбогдол, үр дүнгийн талаар бизнес эрхлэгчдэд зөвлөлгөө өгдөг. Энэ чиглэлээр “Монгол хатгамал” компанийг дэмжин үйл ажиллагаагаа эхлүүлсэн.</p> <p>Хэрэгжилт - 70.0 хувь</p> <p><i>г/ Импортын материалын бөөний худалдааны нэгдсэн сүлжээ байгуулж ажиллуулах, 2003-2004</i></p> <p>- Импортын материалын бөөний худалдааны нэгдсэн сүлжээг “Тахь-Ко”, “Мэжиксют” зэрэг оёдлын томоохон компаниудын дэргэд байгуулан ажиллах талаар санал солилцож байна.</p> <p>Хэрэгжилт - 30.0 хувь</p>

<p>4. Салбарын менежментийг сайжруулж, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэн бүтээмжийн өсөлтийг хангах зорилтын хүрээнд 6 арга хэмжээ төлөвлөсөн.</p> <p>II шатны хэрэгжилтийн дундаж оноо 74</p> <p>(70+70+70+70+90)/5</p>	<p><i>а/ “Хувцас судлалын төв”-ийн үйл ажиллагааг өргөжүүлж, мэргэжлийн боловсон хүчний ур чадвар, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн судалгаа, сургалт явуулах, үйлдвэрлэлийн холбоог бэхжүүлэх, олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэх, 2003-2008</i></p> <p>- ХБНГУ-ын техникийн хамтын ажиллагааны “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих” төсөлд “Хувцас, судлалын төв”-ийг хамруулж, мэргэжилтнүүдийг хувцасны хийц, загварын сургалтад хамруулсан.</p> <p style="text-align: right;"><i>Хэрэгжилт – 70.0 хувь</i></p> <p><i>б/ Хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагаа, ажлын байрны эрүүл ахуйн шаардлагын стандартыг үйлдвэрлэлийн бүхий л шат дамжлагад мөрдөн ажиллаж байгаа эсэхэд хатуу хяналт тавих, стандартыг шинэчлэн сайжруулах арга хэмжээ авах, 2003-2005</i></p> <p>- Улсын мэргэжлийн хяналтын газартай хамтран оёдлын салбарт үйл ажиллагаа явуулж буй 22 үйлдвэр аж ахуйн нэгжид хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагаа, ажлын байрны эрүүл ахуйн шаардлагын биелэлтийн талаар шалгалт хийсэн.</p> <p style="text-align: right;"><i>Хэрэгжилт – 70.0 хувь</i></p> <p><i>в/ Үйлдвэрлэл дундын загвар зохион бүтээх төвийг ажиллуулах, 2004-2008</i></p> <p>- ХБНГУ-ын техникийн хамтын ажиллагааны “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих” төсөлд “Хувцас, судлалын төв”-ийг хамруулж, мэргэжилтнүүдийг хувцасны хийц, загварын сургалтад хамруулсан.</p> <p style="text-align: right;"><i>Хэрэгжилт – 70.0 хувь</i></p> <p><i>г/ ISO-9000 стандартыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, бүтээгдэхүүний чанарын шаардлагын стандартыг олон улсын стандартад нийцүүлэн үндэсний болгон мөрдүүлэх ажлыг зохион байгуулах, 2004-2008</i></p> <p>- Хувцас зохион бүтээлт, загварын ISO стандартуудыг үндэсний болгох зорилгоор “Олон улсын стандарт орчуулах тухай гэрээ”-г байгуулан ажиллаж байна.</p> <p style="text-align: right;"><i>Хэрэгжилт – 70.0 хувь</i></p> <p><i>д/ Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1998 оны 20 дугаар зарлигийг хэрэгжүүлэх хүрээнд үйлдвэрлэлийн үр ашиг, бүтээмжийн өсөлтийг хангах, чанарыг сайжруулах бүх нийтийн хөдөлгөөн өрнүүлэх, 2003-2008</i></p> <p>- Үйлдвэрлэлийн үр ашиг, бүтээмжийг дээшлүүлэх хөдөлгөөн өрнүүлэхэд үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийг хамруулах асуудлаар “Оёмол бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоо”-той хамтран ажиллаж байна.</p> <p style="text-align: right;"><i>Хэрэгжилт – 70.0 хувь</i></p> <p><i>е/ Салбарын ажиллагсдын тогтвор суурьшлыг сайжруулах чиглэлийн асуудлыг судалж холбогдох санал боловсруулах</i></p> <p>- Салбарын ажиллагсдын тогтвор, суурьшлыг хангах эрх зүйн орчинг боловсронгуй болгох хүрээнд тус салбарын ажил олгогчдоос нийгмийн даатгалын шимтгэлд төлдөг төлбөрийн 50 хүртэл хувийг улсын хуваарилагдаагүй зардлаас эргүүлэн төлөх тухай Засгийн газрын 2005 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 32 дугаар тогтоолыг батлуулсан. Уг тогтоолын хэрэгжүүлэх хүрээнд Сангийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Үйлдвэр, худалдааны сайдын 2006 оны 1 дүгээр сарын 06-ны өдрийн 08/02/1 дүгээр хамтарсан тушаалаар “Нийгмийн даатгалд төлсөн шимтгэлийг улсын</p>
--	---

		<p>төсвийн хуваарилагдаагүй зардлаас нөхөн олгох журам"-ыг баталсан. Уг журамд заасан шалгуур үзүүлэлтийг хангасан, давхардсан тоогоор 56 аж ахуйн нэгжид 2005 оны 4 сарын 1-нээс 2006 оны 4 сарын 1 хүртэлх хугацаанд ажил олгогчоос төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийн зохих хувь болон 800 гаруй сая төгрөгийг нөхөн олгосон.</p> <p>- Нийгмийн даатгалын багц хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хэсэгт ажиллаж, Нийгмийн даатгалын тухай хуулинд заасан ажил олгогчоос төлж буй нийгмийн даатгалын хувь хэмжээг 6 пунктээр буулган 13 хувь болгохоор хуулийн төслийг боловсруулан УИХ-д өргөн мэдүүлсэн.</p> <p style="text-align: right;"><i>Хэрэгжилт – 90.0 хувь</i></p>
11	<p><i>Дүгнэлт /ололт, дутагдал, анхаарах асуудлууд/</i></p>	<p>“Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл”-д тусгагдсан 4 зорилтын 19 арга хэмжээ төлөвлөгджээ. Хөтөлбөрийн нэгдүгээр үе шатны 2003-2005 оны зорилтын арга хэмжээнүүдийн хэрэгжилт 2005 оны эцсийн байдлаар дунджаар 90 хувьтай байсан.</p> <p>Хоёрдугаар үе шатанд хөтөлбөрийн зорилтын арга хэмжээнүүдийн хэрэгжилт 2008 оны жилийн эцсийн байдлаар 70 хувьтай дүгнэгдэж байна.</p> <p>Оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх зорилгоор худалдааны таатай орчин бий болгох, татвар, санхүү, зээл, даатгалын бодлогоор дэмжих эрх зүйн үндсүүд бүрдэж байна. Гадаад зах зээлд нэвтрэх, худалдааны таатай нөхцөл бүрдүүлэх зорилтын хүрээнд манай оёмол, сүлжмэл бүтээгдэхүүнийг АНУ-тай “Хөнгөлөлтийн ерөнхий систем”-д хамруулах, Канад, ОХУ, БНХАУ-уудтай импортын татварыг бууруулах яриа хэлцэл хийж байна.</p> <p>Гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд нь манай оёдлын салбарын давуу тал, хөнгөлөлтийг илүү ашигласаар ирсэн, үндэсний үйлдвэрлэгч боломжийг ашиглаж чадахгүй байна. Европын холбооны Худалдааны хөнгөлөлтийн ерөнхий системийн нэмэлт хөнгөлөлтийн хүрээнд компаниуд Европын холбооны орнуудад оёмол, сүлжмэлийн бүтээгдэхүүнээ экспортлох сонирхол байгаа ч тэдний захиалгын тоо хэмжээ бага, стандартынх нь шаардлага өндөр байна.</p> <p>Мөн оёмол бүтээгдэхүүний гадаад зах зээлийн талаар судалгаа хийх, өмнөх хийсэн судалгааны үр дүн, зөвлөмжийг бодлого, арга хэмжээний хэрэгжилтэд ашиглах талаар дутмаг ажиллаж байна.</p> <p>Оёмол бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд шаардлагатай түүхий эд, материалын гаалийн татварын төлөлт, зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр Гаалийн тарифын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг I шатанд шийдвэрлэсэн. Үүний хэрэгжилтэд үр ашгийн тооцоо, судалгаа хийх шаардлагатай.</p> <p>Дотоодын үйлдвэрлэгчдийг санхүү, зээлийн бодлогоор дэмжин ажиллаж байгаа ч санхүүгийн байгууллагуудын зээлийн хүү зээллэгчдийн үйл ажиллагаанд дэмжлэг болохуйц хэмжээгээр буурахгүй, зээлд хамрагдах боломжийг бүрэн олгохгүй байна.</p> <p>Төсвийн болон орон нутгийн өмчөөр бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дотоодын үйлдвэрүүдийн бүтээгдэхүүнийг тэргүүн ээлжинд сонгох, салбарын үйлдвэрүүдийг дэмжлэг Засгийн газрын шийдвэр гарсан ч уг арга хэмжээ хэрэгжихгүй байгаа тул холбогдох талуудтай санал солилцон зохицуулалт хийх арга хэмжээ авах шаардлагатай.</p>

Орон нутагт хувцас захиалгыг жижиг үйлдвэрүүдийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үйлдвэрлэл дундын загвар зохион бүтээх төвийг ажиллуулах, мэргэжлийн боловсон хүчний ур чадвар, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн судалгаа, сургалт явуулах, импортын материалын бөөний худалдааны нэгдсэн сүлжээг байгуулан ажиллах, хувцас зохион бүтээлт, загварын ISO стандартуудыг орчуулах зэрэг арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна. Эдгээр нь хэрэгжүүлэх хөрөнгө батлагдахгүй байгаад ч холбоотой байна.

Үр дүнгийн статистик үзүүлэлт:

Хөтөлбөрт тусгасан *“Бүтээгдэхүүний экспорт тогтвортой нэмэгдэж, оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн дэлхийн зах зээлд эзлэх байр суурь өснө”* гэсэн хүлээгдэж буй үр дүнгийн статистик үзүүлэлтийн хувьд *“Оёмол, сүлжмэл бүтээгдэхүүн болон хувцасны тухай хэлэлцээр”* 2004 онд дуусгавар болон гадаадын захиалга жил бүр багассанаас сүүлийн 4 жилд оёмол, сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспорт буурсаар байна.

Экспорт

- БТКУС-ийн 62-кодтой Оёмол хувцас, эдлэлийн экспорт 2006 онд 39808.0, 2007 онд 24,714.1 мян.ам.долл, 2008 оны урьдчилсан гүйцэтгэлээр 10,592.6 мян.ам.долл болж, өмнөх оныхоос 2007 онд 37 хувиар, 2008 онд 57 хувиар буурсан.

- Оёмол хувцас, эдлэлийн экспорт нь нийт экспортын 2006 онд 2.6, 2007 онд 1.3 хувийг, 2008 онд 0.4 хувийг эзлэв.

Үйлдвэрлэлт

- Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалтын үйлдвэрлэл нь боловсруулах аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд 2005 онд 10.3 хувийг эзэлж байсан бол 2006 онд 7.8 хувь, 2007 онд 4.6 хувь, 2008 онд 2 хувийг эзлэх болжээ.

- Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалтын үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 2005 онд 31254.1 сая төгрөг байсан бол 2006 онд 26847.2, 2007 онд 23486.6 сая төгрөг болж, өмнөх оныхоос 2006 онд 14.1 хувиар, 2007 онд 12.5 хувиар буурчээ. 2008 оны урьдчилсан гүйцэтгэлээр 16340.9 сая төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад 26 орчим хувиар буурсан.

Ажиллах хүчин

- Салбарын хөдөлмөрийн бүтээмж 2007 онд 2005 оны зэрэгцүүлэх үнээр 4469.5 мянган төгрөг болж, өмнөх оныхоос 17 хувиар буурчээ. 2008 оны урьдчилсан гүйцэтгэлээр 37 хувиар өсчээ.

- Уг салбарт ажиллагсдын тоо 2005 онд 11029.0, 2006 онд 4908.0, 2007 онд 4669.0, 2008 оны урьдчилсан гүйцэтгэлээр 2556 болж, өмнөх оныхоос 2006 онд 55, 2007 онд 4.8, 2008 онд 45 хувиар буурчээ.

Зөвлөмж:

- Оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өнөөгийн байдлын үнэлгээ хийх, хөгжлийн стратегийг боловсруулах, оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх талаар бий болсон таатай нөхцөлийг ашиглах арга хэмжээг эрчимжүүлэх,

- Монголын оёмол бүтээгдэхүүнийг хөнгөлөлтийн ерөнхий системд хамруулах, импортын татварыг бууруулах талаар улс орнуудтай хийгдэж буй яриа хэлцлийг эрчимжүүлэн үр дүнд хүргэх,

		<ul style="list-style-type: none"> - Салбарын менежментийг сайжруулж, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэн бүтээмжийн өсөлтийг хангах, хувцас захиалга, засварын болон үндэсний хувцас үйлдвэрлэх жижиг, дунд үйлдвэрийг орон нутагт хөгжүүлэхэд санхүү, зээлийн дэмжлэг үзүүлэх зорилтын арга хэмжээний хэрэгжилт удаашралтай байгаад анхаарах, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг цаг хугацаанд авах асуудлыг шийдвэрлэх, - Хөтөлбөрийг хэрэгжүүлэх III үе шатны арга хэмжээний төлөвлөгөөг оны хуваарьтай үр дүнгийн шалгуур үзүүлэлт, хөрөнгийн эх үүсвэрийн хамт боловсруулан батлуулах, - Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланд хүрсэн үр дүн, шаардагдах санхүүжилтийн шийдвэрлэлт, түүний зарцуулалтын талаархи мэдээллийг тусгах.
12	<i>Хүлээгдэж буй үр дүндээ хүрээгүй бол шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйлс</i>	Хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулагдах хөрөнгийн эх үүсвэрийг цаг хугацаанд олгогдохгүй байгаа нь хүлээгдэж буй үр дүндээ хүрээгүй гол шалтгаан болж байна.
13	<i>Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын талаархи үнэлгээ</i>	Үндэсний үйлдвэрүүдийн үйл ажиллагааг уялдуулан салбарын менежментийг сайжруулах, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэн бүтээмжийн өсөлтийг хангах талаар санаачлагатай ажиллах
14	<i>Хөтөлбөрийн талаархи яамны санал</i>	<ul style="list-style-type: none"> - Оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн тогтвортой хөгжлийн стратеги боловсруулах, “Оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх” хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, - Хөтөлбөрийг хэрэгжүүлэх III үе шатны арга хэмжээний төлөвлөгөөг оны хуваарьтай үр дүнгийн шалгуур үзүүлэлт, хэрэгжилтэд шаардагдах санхүүжилтийг тодорхой тусган боловсруулан батлуулах, уг санхүүжилтийг цаг хугацаанд гаргуулах асуудлыг Сангийн яам, Засгийн газарт оруулан дэмжлэг авах.

Танилцсан:

МХШҮГ-ын дарга

Л.Баяртулга

Хяналт-шинжилгээний үнэлгээ, зөвлөмж өгсөн:

МХШҮХ-ийн ахлах мэргэжилтэн

Д.Алтанлит